



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 5/16

Хэрлэн сум

Гэрээгээр ажил гүйцэтгүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.17, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндэсний хөтөлбөрүүд, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон аймаг, сумын Засаг даргын мөрийн хөтөлбөр зэрэг баримт бичгүүдээр дамжин хэрэгжиж байгаа төрийн үйлчилгээний иргэдийн амьдралд үзүүлж буй нөлөөг тандан судлаж, дараагийн шатны авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны бодлого, төлөвлөгөөнд тусгах зорилго бүхий хэрэглэгчийн үнэлгээний судалгааг сум, тосгон бүрт насанд хүрсэн хүн амын 5-аас доошгүй хувийг хамруулан авч, нэгтгэн дүгнэх ажлыг "Ажил олгогч эздийн холбоо" төрийн бус байгууллалатай гэрээ байгуулан гүйцэтгүүлсүгэй.

Хоёр. Гэрээний үндсэн дээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд зориулж 250000 /хоёр зуун тавин мянган/ төгрөгийг зарцуулсугай.

Гурав. Дээрх зардлыг аймгийн Засаг даргын нөөц сангийн болзошгүй зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Санхүү төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 100